



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/52

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1, сумын Засаг даргын зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын Онцгой комиссын гишүүдийн хувцас худалдан авахад 800000 /найман зуун мянга/ төгрөг, Засаг даргын Тамгын газрын автомашинуудын техник хэрэгсэл, сэлбэг худалдан авахад 3800000 /гурван сая найман зуун мянга/, “Бүжинхэн” ХХК-ийн цэцэрлэгийн урсгал засварын зардалд 600000 /зургаан зуун мянга/ төгрөг, золбин нохой, сэг зэм устгалын зардалд 1944000 /нэг сая есөн зуун дөчин дөрвөн мянга/, шатахууны зардалд 1000000 /нэг сая/ төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх ажлуудад зарцуулагдах 8144000 /найман сая нэг зуун дөчин дөрвөн мянга/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг нягтлан бодогч /Б.Түвшинжаргал/-д зөвшөөрсүгэй.

3. Холбогдох ажлыг зохион байгуулж, санхүүгийн баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг нягтлан бодогч /Б.Түвшинжаргал/, нярав /В.Гэрэлтуяа/ нарт, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Отгонжаргал/-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  П.ГАНЧИМЭГ



42121-381